

УЛС ТӨРИЙН НАМЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Ж.Жаргал
МУБИС-ийн ТНУС-ийн Улс төр судлал, социологийн
тэнхимийн багш, доктор (Ph.D)



Улс төрийн намын гишүүнчлэлийн асуудлууд

- Улс төрийн намын гишүүнчлэлийн тухай
- Улс төрийн намын гишүүнчлэлийн төлөв байдал дэлхий дахинд
- Улс төрийн намын гишүүнчлэл ба гишүүдийн нас, хүйс, боловсролын харьцаа
- Улс төрийн намын гишүүнчлэл буурч байгаагийн шалтгаанууд
- Улс төрийн намын гишүүнчлэл ба санхүүжилт
- Улс төрийн намын хөгжил, чиг хандлага (кибер намууд, сошиал медиа хэрэглээ)

Улс төрийн намд гишүүд, дэмжигчид яагаад хэрэгтэй вэ

- Легитим байдал нь илүү баталгаажина.
- Гишүүд дэмжигчид нь намд хэрэгцээтэй төрөл бүрийн нөөцийг бий болгож байдаг.
- Сонгуулийн кампанит ажлын үед илүү амжилт олох магадлал нэмэгдэнэ.
- Шинэ гишүүн, дэмжигчийг олж авахад туслана.
- Гишүүнчлэлийн татвараас орлогын нэг эх үүсвэр нь бүрдэнэ.
- Боловсролтой, чадварлаг боловсон хүчин, нэр дэвшигчдийг бүрдүүлнэ.
- Намын үзэл суртал, мөрийн хөтөлбөр, платформын дэмжлэг авна.
- Нийгмийн бүлэг, сонгогчидтой холбох гүүр болж өгнө.
- Нам дахь сайн дурын хөдөлмөр эрхлэлт.

Гишүүн байх нь ямар хэрэгтэй вэ

- Улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх
- Улс төрийн талаар илүү ойлголттой болох (сонин, сэтгүүл, сургалт)
- Улс төрд оролцох (хурал, цуглаан)
- Хувийн улс төрийн зорилгоо биелүүлэх (төрийн албанд очих)
- Нийгмийн хэрэгцээгээ хангах (бусад гишүүдтэй ойртон танилцах, янз бүрийн спорт, танилцах арга хэмжээнд оролцох)

Намын гишүүнчлэлийн нийтлэг загвар (Улс төрийн намын гишүүнчлэл: Намын нийгмийн өмнө хүлээх үүрэг. IDEA)

Намын гишүүд дэмжигчдийг дотор нь:

- Намын кадр: сонгогдсон албан тушаалтан буюу намд алба хашдаг гишүүд;
- Идэвхитэй гишүүд: бодлого боловсруулах хуралд оролцож олон нийтэд хүрэх, тэднийг дагуулах, улс төрийн намыг өргөжүүлэн тэлэх ажилд оролцдог гишүүд;
- Оролцоо бүхий гишүүд: голцуу намын зөвлөлдөх хурал зэрэг чухал хурлуудад оролцдог гишүүд;
- Дэмжигч гишүүд: гишүүнчлэлийн төлбөр төлдөг ч бусад байдлаар намын үйл ажиллагаанд төдийлөн оролцдоггүй гишүүд;
- Албан бус дэмжигчид: намд албан ёсны гишүүнчлэлгүй ч тухайн намын төлөө саналаа өгч, мөнгө хандивлах болон сонгуулийн компанит ажилд тухайн намыг дэмжиж ажилладаг.

Улс төрийн намын гишүүнчлэлийн байдал дэлхий дахинд

Улс төрийн намын гишүүнчлэлийн асуудлаар томоохон судалгаанууд олон удаа хийгдсэн. Тухайлбал Paul Whiteley (2004) дэлхийн ардчилсан 36 орны улс төрийн намуудын гишүүнчлэлийн төлөв байдлыг судласан. Тэрээр гишүүнчлэлийн бууралтын шалтгааныг:

1. Төр, нам хоёрын харилцаа улам ойртсон
2. Улс төрийн нам дахь оролцоо шинэ хэлбэрийн оролцоонд дарагдах болсонтой холбожээ.



Европын орнууд дах намын гишүүнчлэл

- Европын орнуудад улс төрийн намын гишүүнчлэл улам бүр буурсаар байна. Энэ талаар олон тооны судалгаа хийгджээ. (Katz et al. 1992; Mair, 1994; Whiteley and Seyd, 1998; Scarrow, 2000; Mair and Van Biezen, 2001; Dalton, 2005).
- Хамгийн сүүлд 2012 онд Mair болон Van Biezen нар 2001 онд намын гишүүнчлэлээр Европын 20 орныг хамарсан судалгааны ажлаа өргөжүүлж 7 орныг нэмэж дахин судалжээ.
- 2001 онтой харьцуулахад дундаж гишүүнчлэл 5 аас 4.7 хувь болж буурсан байна. Харин өмнөх судалгаанд хамрагдсан 20 орны хувьд бүр 4.3 хувь болж буурчээ.
- 1950-1970 –иад оныг бид Европын орнуудын улс төрийн намын алтан үе гэж нэрлэж болох юм. Энэ үеэс хойш гишүүнчлэл аажмаар буурсаар ирсэн байна. Зүүн болон Төв европын орнуудад гишүүнчлэл хамгийн хүчтэй буурч байна.
- Намын систем хүчтэй явж ирсэн Скандинавын орнуудад ч 1970-1980-аад оноос гишүүнчлэл буурсан бөгөөд 1960 онд Дани улсын 5 хүн тутмын 1 нь намын харьяалалтай байсан бол 1990 оны сүүлч үед 20 хүн тутмын 1 болж буурчээ.

Үргэлжлэл

- Европын улс төрийн намууд гишүүнчлэлээ алдаж массын намын төрхөө гээж байгаа ч Италийн Лега Норд намын хувьд маш хүчтэй, өндөр зохион байгуулагдсан массын намын бүтцийг амжилттай хадгалсан хэвээр байна.
- Германы улс төрийн намууд мөн адил гишүүнчлэлийн хувьд өндөр хэвээр байгаа бөгөөд шалтгаан нь төрийн татаас нь тэдний гишүүнчлэлээс орж ирэх орлоготой шууд харилцан хамааралтай байдагтай холбоотой.
- Улс төрийн намууд гишүүдээ нэмэгдүүлэхээс илүүтэй өргөн олон түмэнд хандсан сонгуулийн илүү үр дүнтэй, оновчтой кампанит ажил, маркетингийн бодлогод анхаарах болжээ.

Европын улс төрийн намуудын гишүүнчлэл (сонгогчдын дунд эзлэх хувь)

Улс	1980	1990	1999	2008
Австри	28,48	23,71	17,66	17,27
Чех		7,04	3,44	1,99
Франц	5,05	2,98	1,57	1,85
Герман	4,52	3,89	2,93	2,30
Итали	9,66	9,10	4,05	5,57
Норвеги	15,35	13,13	7,31	5,04
Испани	1,20	2,07	3,42	4,36
Их Британи	4,12	2,63	1,92	1,21
Польш			1,15	0,99

Van Biezen, Peter Mair. 2012

Улс төрийн намын гишүүнчлэл ба нас

- Хүн амын ахимаг настай хэсэг нь улс төрийн намын гишүүн болдог нь ажиглагдаж байна. Залуу гишүүдтэй улс төрийн намтай улсууд нь шинээр ардчилалд шилжсэн орнууд болох нь судалгаанаас харагдсан байна. Энд Испани, Португали, Польш, Словаки зэрэг улсуудыг нэрлэж болно.
- Залуу үеийг эгнээндээ шинээр нэмж чадахгүйн улмаас гишүүдийн дундаж нас ч нэмэгдсэн байна. Тухайлбал Германы төдийгүй Европын томоохон нам Христийн Ардчилсан Эвслийн (CDU – өдгөө Германы төрийн эрхийг барьж буй нам) гишүүний дундаж нас 54 болсон бөгөөд 20 гишүүн тутамд дөнгөж 1 хүн 30-аас доош настай байна.

	18-30	31-60	61+
Австри	10,4	70,1	19,5
Франц	4,3	61,9	33,8
Их Британи	7,3	38,8	53,9
Португал	28,6	47,2	24,2
Испани	19,1	65,5	15,5

Улс төрийн намын гишүүнчлэл ба хүйс

- Улс төрийн намын гишүүнчлэлд эрэгтэйчүүдийн эзлэх хувь Скандинавын гурван улсаас (Швед, Финланд, Норвеги) бусдад нь илүү байдаг. Францад эмэгтэй нэр дэвшигчийг заавал оруулах хуулийн шахалтын нөлөөгөөр эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдэж байгаа. Латин америкийн орнуудад эмэгтэй гишүүдийн хувь харьцангуй өндөр байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд дөрвөн эмэгтэй ерөнхийлөгч сонгогдсоныг дурдах хэрэгтэй.

	Эрэгтэй
Австри	63,3
Итали	70,5
Норвеги	60
Швед	53,1
Польш	79,9

Sources: Jowell et al 2003; Jowell et al 2005; Widfeldt 1995

Төв болон Латин америкийн орнуудын улс төрийн нам дахь ЭМЭГТЭЙ ГИШҮҮДИЙН ХУВЬ

Table 2: Party membership by sex, 2009 (weighted average)

Country	Women members (%)	Range (%)	Number of parties
Argentina	52	51-53	5
Chile	48	44-53	3
Dominican Republic	36	28-42	5
Guatemala	54	47-57	3
Mexico	47	44-48	4
Paraguay	47	36-52	5
Peru	48	44-50	2
Average	51	28-57	27

Улс төрийн намын гишүүнчлэл ба боловсрол

- Скандинавын орнуудаас бусдад (эсрэгээрээ) нь гишүүд нь дэмжигч болон идэвхтэнүүдээс арай илүү боловсролтой байдаг.

	Боловсролын түвшин (жилээр)	Боловсролын түвшин хүн амын дундаж
Австри	12,3	12,2
Герман	14,3	12,9
Итали	12,1	10,7
Финланд	11,0	12,1
Швед	11,9	12,0

Sources: Jowell et al 2003; Jowell et al 2005; Widfeldt 1995

Улс төрийн намын гишүүнчлэлийн бууралтын шалтгаан

Макро түвшний тайлбар	Мезо түвшний тайлбар
Нийгмийн өөрчлөлт	Намуудын бүтэц, зохион байгуулалтын хувьсал
Индивидуализаци (нийгэм, бүлгээс хараат бус)	Мэргэшсэн
Секуляризаци	Personification (хувийн шинж чанар сайн төлөвшсөн)
Ажилчин ангийн бууралт	ОНМХ
Нийгмийн холбоос суларсан	Гишүүдийн хэрэгцээ багассан

Sources: All tomorrow's parties. Center for European studies.2012

Бусад шалтгаанууд

1. Сонгуулийн ялагдал
2. Удирлага солигдох, нам дах хагарал
3. Залуу үе улс төрийн намуудыг гэхээс илүүтэй нийгмийн хөдөлгөөнийг дэмжих болсон байна.
4. Телевиз суурьтай сонгуулийн кампанит ажил нь улс төрийн намын уламжлалт харилцааны сүвгүүдэд нөлөөлсөн
5. Улс төрийн оролцооны шинэ хэлбэрүүд (facebook, twitter, blog)
6. Хүмүүсийн чөлөөт цаг багассан (Гэр бүл, ажил, найз нөхөд, спорт, бусад арга хэмжээ)
7. Постматериалист залуу үе улс төрийн намуудыг дэмжихгүй байгаа
8. Нийгэм эдийн засгийн хямрал, мөргөлдөөн харьцангуй багассан.

Улс төрийн намын гишүүнчлэл ба санхүүжилт

- Улс төрийн намын санхүүжилтийн уламжлалт хэлбэрийн нэг нь гишүүний татвар байсан бол орчин үед нам дан ганц гишүүний татвараар оршин тогтнохг боломжгүй болж байна.

Table 5: Sources of party funding 2012 (£000s)

	Cons	Lab	Lib Dem	SNP	UKIP	Green	BNP
Membership	747	5,508	890	555	438	247	147
Donations	14,706	5,281	1,708	752	630	519	430
Fundraising	456	649	0	166	23	34	19
Commercial	621	3,373	0	47	51	13	21
Grants	322	6,956	818	171	-	-	-
Affiliations	-	7,965	-	-	-	-	-
Other	7,396	3,592	2,674	609	85	69	31
Total	24,248	33,024	6,024	2,300	1,228	882	647
% member fees	3.1	16.7	14.8	24.1	35.7	28.0	22.7
% donations /fundraising	62.5	18.0	28.4	40.0	53.2	62.7	69.4

Source: Electoral Commission (www.electoralcommission.org)

Улс төрийн намын хөгжил, чиг хандлага ба гишүүнчлэл

- Кибер намууд (Cyber party). Намын энэ хэв маяг улам хүчээ авч байна.
 - 1990 оны сүүлч үеэс эх үндэстэй, асар хурдацтай хөгжиж буй мэдээллийн технологийн хөгжил, интернет, web д суурилсан
 - Маш бага гишүүдтэй, аль болох олон дэмжигчийг өөртөө татахыг зорьдог
 - Уян хатан олон сувгаар гишүүд, дэмжигчид сонгогчидтойгоо холбогдох боломжтой
 - Илүү хямд кампанит ажил явуулах боломж
- “Далайн дээрэмчдийн” нам (Pirate party)
 - Намын эх үндэс нь интернет орчин дахь мэдээллийг үнэ төлбөргүй олж авах, татах, хэрэглэх явдлаас эх үндэстэй.
 - Тэд интернетийн орчин дахь ил тод мэдээлэл, мэдээлэл үнэгүй солилцох эрхийн төлөө ажилладаг.
 - Бусад намуудаас онцлогтой нь залуу үеийнхэний дэмжлэгийг маш сайн авч байгаа.
 - 2011 оны Берлин хотын болон 2012 оны Saarland ийн сонгуульд тэдний төлөө 18-34 насны залуучууд хамгийн өндөр хувьтай санал өгчээ.
 - Сонгууль, улс төрийн намуудаас хөндийрсөн залуу үеийг татаж байгаа.

Five Star Movement хөдөлгөөн (Кибер намын хамгийн тод жишээ)

- “Movimento 5 Stelle” энэ бол шинэ төрлийн улс төрийн нам юм. Үнэндээ нам гэхэд тун хэцүү
- Италийн хошин шогч, блоггер Беффе Грилогийн үндэслэсэн онлайн хөдөлгөөн юм.
- Албан ёсны гишүүнчлэл, төвлөрсөн бүтэц, зохион байгуулалт байхгүй.
- Асар том Facebook групп, онлайн уулзалтын тусламжтайгаар үйл ажиллагаа нь зохион байгуулагддаг.
- 2013 оны италийн парламентын сонгуулийн үеэр хэвлэлийнхэнд нэг ч ярилцлага өгөөгүй бөгөөд өөрийн блоогоороо дамжин харьцаж байв.
- PR бүхий л дүрмийг зөрчиж улс төрийн тавцанд өрсөлдөж байгаа боловч сонгуульд дөрвөн итали тутмын нэг нь тэдний төлөө саналаа өгсөн.
- Байгуулагдаад 4 жил болоогүй ч доод танхимд 106, дээд танхимд 50 суудал авч 400.000 гишүүдийг эгнээндээ нэгтгээд байна.

Их Британий улс төрийн намуудын албан ёсны гишүүнчлэл ба Facebook дагагчид

	Formal party members²²	Facebook likes of official party account²³	Unique Facebook likes of official party or leader pages²⁴
Conservative	130,000-170,000	159,044	217,900
Labour	193,000	143,244	132,840
Liberal Democrats	49,000	92,078	129,340

Sources: Bartlett, Bennett, virtually members, 2013

Их Британий улс төрийн намуудын албан ёсны гишүүнчлэл ба twitter дагагчид

	Formal party members²⁶	Twitter followers of official party account²⁷	Unique Twitter followers of all MPs (minus leader)²⁸	Unique Twitter follower of all MPs unique to party (minus leader)²⁹
Conservative	130,000-170,000	82,311	614,719 (401,882)	430,893 (272,356)
Labour	193,000	80,752	503,881 (413,691)	316,237 (280,834)
Lib Dem	49,000	41,073	173,184 (88,604)	68,335 (35,255)

Sources: Bartlett, Bennett, virtually members, 2013

Цаашид анхаарах зүйлс

- Монголын улс төрийн намын гишүүнчлэлийн талаархи суурь судалгаа (mapping - зураглал) (нас, хүйс, жендер, боловсрол, орлого, ажил эрхлэлт, оролцоо идэвхи г.м)
- Нам ямар бодлого баримтлах вэ ? (Гишүүнчлэл буурч, массын намуудын цаг үе дуусч байгаа ч улс төрийн намуудад гишүүнчлэл хэрэгтэй, энэ нь судалгаануудаас харагдаж байна.)
- Улс төрийн намын сул гишүүнчлэлтэй, бүтэц зохион байгуулалт нь америк маягийн улс төрийн династи (political dynasties), гэр бүлийн нэр дэвшигчид, плутократуудын (plutocracy) ноёрхолд хүргэх эрсдэлтэй.
- Монголын улс төрийн намууд өөрийн онцлогт тохирсон санхүүжилтийн зөв загварыг сонгох (төрийн санхүүжилт, хандив: эерэг сөрөг тал)
- Нийгмийн өөрчлөлтөнд дасан зохицох, хурдан хариу үйлдэл үзүүлэх, харилцаа холбооны уян хатан, шуурхай, түгээмэл сувгуудийг ашиглах